



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 11

Номгон

Төсвийн төсөлд шатахууны зардлыг
үнэн бодитой төлөвлөн ажиллах
тухай

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан 07/02 тоот удирдамжийн дагуу Говийн сумдын ЗДТГ-ын 2022 оны шатах тослох материалын зардлын төлөвлөлтөд хийсэн дотоод аудитын үр дүнгээр сумдын Засаг даргын Тамгын газрын шатахууны төсвийг бодитой төлөвлөж хүргүүлээгүй байна.

Төсвийн тухай хууль болон бусад тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө, санхүүгийн сахилга, хариуцлага, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 65 дугаар зүйлийн 65.1.4, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 1 дүгээр хэсгийн 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

Нэг.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст:

1.1.Шатах тослох материалын зардлын төслийг хүлээн авч, санхүүжүүлэхдээ сумын өрх, хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан үзэх.

Хоёр.Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт:

2.1.Байгууллагын гүйцэтгэлийн болон стратеги төлөвлөгөөний эрсдэлийг арилгахад чиглүүлж шатах тослох материалын төсвийг төлөвлөх.

2.2.Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон сургалтын хөтөлбөрт шатах тослох материалыг зарцуулах арга хэмжээ, санхүүжилтийг тодорхой тусгаж өгөх.

2.3.Гамшиг, мал үржлийн тасгийн төлөвлөгөө, бусад хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан төсвийн төслийг боловсруулж хүргүүлэх.

2.4.Урьд оны гүйцэтгэлд тулгуурлан төсвийг төлөвлөдөг байдлыг арилгах.

842402003
Document3

2.5.Төсвийг бодитой, зөв төлөвлөж Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулах шатахууны зардлыг зогсоон хэмнэж ажиллах.

2.6.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалыг хэрэгжүүлж, жишиг нормоо тогтоон, түүний дагуу төслөө хүргүүлэх.

Гурав.Сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэн зөв, бодитой боловсруулах, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 2.3-т “Төлөвлөгөө нь стратеги төлөвлөгөө болон дараах бодлогын баримт бичиг, төлөвлөгөөнд үндэслэнэ”, 2.3.1-т “Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ”, 2.3.2-т “төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр”, 2.3.3-т “төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”, 2.3.4-т “өмнөх оны төлөвлөгөөнөөс биелээгүй, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ”, 2.4-т “Төлөвлөгөөг боловсруулахдаа дараах зарчмыг баримтална”, 2.4.1-т “Стратеги төлөвлөгөөнд тусгасан зорилтын хүрээнд хүлээгдэж байгаа өөрчлөлтийг илэрхийлсэн тодорхой зорилт, арга хэмжээг агуулсан байх бөгөөд зорилт, арга хэмжээ нь хоорондоо уялдсан байх”, 2.4.4-т “Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг арга хэмжээ тус бүрээр тусгасан байх” зэрэг заалтын хэрэгжилтийг хангаж, ажиллахыг үүрэг болгосугай.

Дөрөв.Албан даалгаврын хэрэгжилтийг 2024 оны 08 дугаар сарын 05-ны дотор тайлагнаж, хариуг Санхүүгийн хяналт дотоод аудитын албанд ирүүлэхийг сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.

Тав. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН